

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-6</i>

<i>1.Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай</i>	<i>4-6</i>
--	-------------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 07 дугаар сарын 09-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 01 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж, Н.Учрал, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, М.Нарантуяа-Нара.

Нэг.Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна гэж заасныг баримтлан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг болон бусад Байнгын хорооны гишүүдийн саналыг үндэслэн Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Б.Энхбаяр, О.Номинчимэг, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд нарыг оруулахаар танилцуулав.

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай танилцуулгыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд,

Л.Соронзонболд, Б.Энхбаяр, О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Ж.Баярмаа нарыг оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	14
Татгалзсан	2
Бүгд	16

87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхимд 13 цаг 01 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ингээд Байнгын хорооны гишүүд олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя аа. Ирц Дамдины Цогтбаатар, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр гэсэн ирцтэйгээр ирц хангагдсан байна аа. 64 хувьтай байна ирц.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя аа.

Байнгын хорооны хуралдаанаар дэд хорооны асуудал яригдана. Улсын их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал орж ирж байна аа. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна аа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа тэгвэл оръё. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Халдашгүй байдлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна гэж заасныг баримтлан УИХ дахь МАН-ын бүлэг, УИХ дахь АН-ын бүлэг болон бусад Байнгын хорооны гишүүдийн саналыг үндэслэн Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Пүрэвжавын Сайнзориг, Баттөмөрийн Энхбаяр, Одсүрэнгийн Номинчимэг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Сүхбаатарын Эрдэнэболд нарыг оруулахаар танилцуулж байна аа.

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? За тэгээд энэ одоо юу бүрэлдэхүүнтэй холбогдсон танилцуулгыг Монгол Ардын бүлгийн МАН-ын их хурал дахь бүлгийн дэд дарга Ариунзаяа дарга танилцуулна аа. Ариунзаяа даргын микрофоныг өгье өө.

А.Ариунзаяа: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Хүний эрхийн дэд хороо байгуулагдаж

байна. Хүний эрхийн дэд хороо 10 хүний бүрэлдэхүүнтэй бүрэлдэхүүнийг танилцуулж байна аа.

Нэг.Хүрэлбаатарын Баасанжаргал, хоёр, Пүрэвжавын Сайнзориг, гурав, Баттөмөрийн Энхбаяр, дөрөв, Одсүрэнгийн Номинчимэг, Тав, Лхагвасүрэнгийн Соронзонболд, зургаа, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, долоо, Гончигдоржийн Уянгахишиг, найм, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, ес, Оюунсайханы Алтангэрэл, арав, Сүхбаатарын Эрдэнэболд. Танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Ариунзаяа даргад баярлалаа. Ингээд энэ бүрэлдэхүүнтэй холбогдолтой асуудлаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Баярмаа гишүүнээр тасаллаа. За Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Яах вэ ерөнхийдөө сая ойлголцсон уу, ойлголцоогүй юу? Би уг нь энэ Хүний эрхийн дэд хороонд оръё гэж бодсон юм. Тэгсэн чинь нөгөө тооных нь лимит нь тулчаад байгаа юм байна тийм үү? Тэгэхээр одоо яана гэсэн үг юм бол?

Д.Цогтбаатар: Тэгье тэгье. Тэгвэл бүлгийн дарга дэд даргад юу өгье Ариунзаяа даргын микрофоныг өгье. Надад бол ямар нэгэн татгалзах асуудал алга.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дэргэд байгаа дэд хороод Байнгын хорооныхоо 2-ны 1-ээс ихгүй байх хуультай. Тэгэхээр Байнгын хорооны бүрэлдэхүүн болбол одоо 25 байна тиймээ. Тэгэхээр 12 байж болно. Үндсэндээ бүрэлдэхүүнийг бас сонгохдоо Улсын Их Хурал дахь намуудын суудлын харьцаагаар хувь хэмжээгээр нь бас рейшио барьж байгаа. Ийм учраас Ардын намаас нэг хүн нэмж орж ирж байж тэгээд Баярмааг оруулж болно. Баярмагнайн Баярбаатар гишүүнийг оруулаад, мөн Жудагийн Баярмаа гишүүнийг оруулж болж байна аа тийм.

Д.Цогтбаатар: Тэгвэл одоо энэ дээр чинь дэгээрээ бид нар нэмээд тийм. Тэгвэл Ариунзаяа дарга бол татгалзах нөгөө гол оруулж байгаа хүн маань татгалзах юмгүй юм чинь нэмээд бид нар тэгвэл уншаад л явчихъя тэгэх үү? За тэгвэл энд асуулт асууж, үг хэлж гишүүд дууслаа.

Одоо саяын саналыг тусгаад нэрсийг уншиж танилцуулъя. Тэгэхлээр Монгол улсын би одоо уншаад нөгөө шинэчилсэн байдлаар танилцуулаадахъя.

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Мөнхтөрийн Нарантуяа, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Баттөмөрийн Энхбаяр, Оюунсайханы Алтангэрэл, Баярбаатар дарга, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа гэсэн ийм одоо 12 гишүүнээс бүрдэхээр болж байна. Тэгээд энүүгээр баталъя гэсэн томъёоллоор ийм бүрэлдэхүүнээр баталъя гэсэн томъёоллоор санал хураалтаа хийе. Ингээд санал хураалтад гишүүд бэлдэнэ үү. Тэгээд саяын уншсан юу бүрэлдэхүүнтэйгээр дэд хороог байгуулъя аа.

Нэрсийн жагсаалтыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

87.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн гишүүн Баасанжаргал гишүүн танилцуулна аа. Хүрэлбаатарын Баасанжаргал.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ талархал илэрхийлье.

Гишүүд ээ. Энэ 16 цагаас манай Хууль зүйн байнгын хорооны хурал байгаа шүү. Тэрийг бас зарлах ёстой юм байна.

13:09

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ